

## ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**И. В. КОВАЛЕНКО «АЗИЙН ЭНХ ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ТӨЛӨӨ ЗХУ-ЫН ТЭМЦЭЛ»****М.. Прогресс хэвлэлийн газар, 1981**

Дэлхийн бүх хуурай газрын 30 хувь, хүн амын тэн хагасаас илүү нь оршин суудаг өргөн уудам Ази тивийн ард түмэн олон зууны туршид колоничлолын хүнд хэцүү талхигдалд байсан билээ. Аугаа их Октябрийн социалист их хувьсгал хүн төрөлхтний хөгжилд шинэ эрин үеийг нээснээр Ази дахь империализм колонийн систем сүйрлийн шатандаа орж, дорно дахины улс түмний хувь заяанд үндсэн эргэлт гарах болов. Үүний зэрэгцээ дэлхийн II дайнд ЗХУ шийдвэрлэх үүрэг гүйцэтгэн германы фашизм, японы милитаризмыг бут цохисон нь Ази тивд улам ч таатай нөхцөл бүрдүүлсэн боловч дайнаас хойш энэ тивд мөргөлдөөний голomt арилсангүй. Ийм учраас бат бэх энх тайван, бүх нийтийн аюулгүй байдлыг Ази тивд тогтоох явдал энэ тивийн ард түмний хувьд амин чухал асуудал болж байна. Энэтхэг-хятадын хойгийн ард түмний эсрэг империалистуудаас явуулж ирсэн удаан жилийн түрэмгийлэл, хятадын удирдлагаас энэ районд явуулж байгаа хагалан бутаргах үйл ажиллагаа Ази тивийн бүх нийтийн аюулгүй байдалд ноцтой заналхийлэл учруулж байсан ба учруулсаар байна. Учир иймд нутаг дэвсгэрийн гуравны хоёр нь Ази тивд байдаг, эдийн засаг, түүх соёлын талаар эртнээс нягт холбоотой явж ирсэн ЗХУ энэ тивийн энх тайван аюулгүй байдлын төлөө байнгын анхаарал тавьж ирсэн юм. Иван Коваленкогийн «Азийн энх тайван аюулгүй байдлын төлөө ЗХУ-ын тэмцэл» номонд энэ тухай тодорхой баримтанд тулгуурлаж онолын үндэстэй өгүүлжээ. Уншигчдад толилуулан буй энэ номд зохиогч Азийн энх тайван, аюулгүй байдлын төлөө Зөвлөлт улсын тэмцлийн үе шатуудыг тодорхойлоод, энэ үйл хэрэгт ЗХУ-ын оруулсан их хувь нэмэр, олон улсын империалист түрэмгийлэлд хамтын хүчээр цохилт өгөх явдалд тэднээс гүйцэтгэсэн үүргийг тодорхой баримтанд тулгуурлан тайлбарлаж, Ази тивийн энх тайвныг энэ бүс нутгийн улс орнууд хамтран хамгаалахаас эрхэм зүйл байхгүй гэдгийг нотлон харуулжээ. 1969 оны коммунист ажилчны намуудын зөв-

лөлгөөн дээр Л. И. Брежнев ЗХУ-аас Азийн энх тайван аюулгүй байдлын асуудалд хандах шинэ хандлагыг заасан юм. «Орчин үеийн олон улсын амин чухал асуудлууд нь дэлхийн шинэ дайн дэгдээх, зэвсэгт мөргөлдөөн өдөөх аюул нөмрөн байгаа дөлхий бөмбөрцгийн тэр хэсэгт хамтын аюулгүй байдлын систем тогтоох явдлыг биднээс хөндийрүүлэх биш харин ч тулгамдсан зорилт болгон тавьж байна. Тийм систем бол оршин байгаа цэрэг-улс төрийн бүлэглэлүүдийг халж өөрчлөх шилдэг хэрэгсэл мөн. ...Азийн хамтын аюулгүй байдлын систем байгуулах зорилтыг үйл явцын хөгжилт, ээлжийн асуудал болгон дэвшүүлэн тавина гэж бид үзэж байна»<sup>1</sup> гэж Л. И. Брежнев цохон заасан юм. ЗХУ-ын энэ оновчтой санаачилга Азийн ард түмнээс өөрийн тивд энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхийн төлөө явуулсан тэмцлийн туршлага дээр тулгуурласан юм. Тухайлбал, Хятад дахь Төвдийн район ба Энэтхэгийн хоорондын харилцааны тухай БНЭУ, БНХАУ хоёрын бүр 1954 онд байгуулсан хэлэлцээрийн удиртгалд зарлан тунхагласан энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим («панча шила») Азийн оонуудын шинэ маягийн харилцааны үндсийг тавьж өгсөн билээ. Гэвч энэ нь зөвхөн эхлэл баясан бөгөөд 1955 онд Ази, Африкийн 29 орны төлөөлөгчид Баидунгийн бага хурлаас гаргасан тунхаглалдаа дээрх таван зарчмыг хөгжүүлэн нийгмийн янз бүрийн байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших арван зарчмыг боловсруулсан юм. Түүнчилэн эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, Ази, Африкийн эв санааны нэгдлийн хөдөлгөөн зэрэг нь Азид энх тайвныг бэхжүүлэх үйл хэрэгт чухал хувь нэмэр оруулсан, оруулсаар ч байгааг уг номд тэмдэглэжээ. Түүнээс гадна Азийн тодорхой районыг, тухайлбал, Зүүн Өмнөд Азийг цөмийн зэвсэггүй бүс болгох, Энэтхэгийн далайг энх тайван бүс болгохын төлөө хөдөлгөөн нь Азийн энхийг эрхэмлэгч хүчний талархлыг зүй ёсоор хүлээж байна. Азийн хамтын

<sup>1</sup>А. И. Брежнев. Лениний зааснаар, 2 дугаар боть. № 7. 1970; 413 дугаар тал.

аюулгүй байдал нь улс хоорондын харилцаанд хүч хэрэглэх явдлаас татгалзах; олон улсын маргааныг энх тайван аргаар шийдвэрлэх; тусгаар тогтнол, улсуудын хил хязгаарын хөдөлшгүй дархан байдлыг хүндэтгэх; түрэмгийлэх замаар нутаг дэвсгэрийг нь булаан авах явдал гаргуулахгүй байх; дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох; тэгш эрхт эдийн засгийн хамтын ажиллагаа тогтоох, өөрсдийн байгалийн нөөц баялгийг бүрэн эрхтэйгээр эзэмших ба нийгэм-эдийн засгийн өөрчлөлт хийх эрх зэрэг зарчмууд дээр үндэслэсэн байхыг ЗСБНХУ чухалчилдаг юм. Ази тивд энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэхэд улс хоорондын харилцаанд хүч хэрэглэхээс татгалзаад зогсохгүй улс төр, эдийн засаг, үзэл суртлын талаар даралт үзүүлэх шинэ колоничлолын бодлого явуулахаас татгалзах хэрэгтэй гэж зохиогч үзжээ. Шинэ колоничлолын улс төрийн хамгийн дэлгэрсэн арга нь тэгш бус гэрээ, хэлэлцээрүүдийг тулган хүлээлгэх явдал юм. Эдийн засгийн янз бүрийн аргуудыг өргөн ашиглаж байгаагийн дотор «тусламжийн» янз бүрийн программ хэрэгжүүлэх нэрийдлээр шинэ тулгар хөгжиж буй орнуудын эдийн засагт гүнзгий нэвтрэн орж байна.

Эцэст нь Тивийн аюулгүй байдлыг хангах гол арга бол цөмийн зэвсэг хэрэглэх явдлыг хориглохыг оролцуулан зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах явдал гэж зохиогч дүгнэжээ.

ЗХУ Азийн хамтын аюулгүй байдлыг хангах үндсэн зарчмуудыг зөвхөн дэвшүүлээд зогсоогүй уг санаачилгыг амьдралд хэрэгжүүлэх тодорхой арга замыг заасан юм. Азийн улсуудын харилцааг энх тайвнаар зохицуулах. Азид намжмал байдлыг тогтоохын төлөө, зэвсэг хураах цэрэг улс төрийн эвслүүдийн эсрэг Азийн ард түмний тэмцлийг улам идэвхжүүлсний үндсэн дээр уг зорилтыг хэрэгжүүлэх боломжтойг зохиогч түсган харүүлжээ. Мөн Ойрхи Дорнодын хямралыг шударгаар шийдвэрлэх явдал бол Азийн аюулгүй байдлын төлөө тэмцлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэсэн байна.

Ази тивд бат бэх энх тайван тогтоох үйл явцад өнөөгийн хятадын эрх баригчдын их гүрний бодлого ноцтой саад тотгор учруулж байгааг зохиогч цохон тэмдэглэжээ. Тэд их гүрний дээрэнгүй төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх цорын ганц хэрэглүүр бол дайн, зөвхөн дайн бөгөөд харин энх тайвны төлөө тэмцэх, өнөөгийн олон улсын асуудлуудыг энх тайвнаар зохицуулах арга замыг хайх

явдал бол зөвхөн цаг дэмий үрсэн ажил гэж үзэж байна. Энэ төлөвлөгөөний дагуу хятадад олон жилийн турш дайнд бэлтгэх нийт үндэстний хэмжээний кампанит ажил явагдаж байгаа билээ. НҮБ-ын гаргасан мэдээгээр, БНХАУ-ын цэргийн зардал тасралтгүй өсч, одоо улсын төсвийн 40 хувиас даваад байгаа ажээ. Хятадын хуурай замын цэрэг одоо 4,5-5 сая орчим хүнтэй дэлхий дээр хамгийн том арми болсон байна. Тэд 1964 оноос эхлэн атомын ба устөрөгчийн зэвсэг туршсан юм. Гэвч энэ бүхэн хятадын эзлэн түрэмгийлэгчдийн сэтгэлд чамлагдаж байна. Хятадын цэргийн машиныг ЗСБНХУ, социалист бусад орон, шинэ тулгар хөгжиж байгаа улсуудын эсрэг чиглүүлэх зорилгоор байлдааны янз бүрийн техникийг империалистууд Хятадад дуртайяа нийлүүлж байна. Бээжингийнхэн Ази, Номхон далай, Энэтхэгийн далайн орнуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс эрээ цээргүй оролцож, байгаа АНУ-д баяр хүргэж «хамтын аюулгүй байдлыг хангах» тухай япон-америкийн гэрээг Азид «тогтвортой байдлыг» бий болгох чухал хүчин зүйл мөн хэмээн шагшин магтаж, Азийн нилээд оронд байгаа америкийн цэргийн баазыг устгахыг эсэргүүцэж байна. Тэд «намжмал байдал бол ард түмнийг мунхруулагч хар тамхи мөн» гэсэн лоозон дэвшүүлэхээс ч буцсангүй.<sup>2</sup>

Хятадын жанжлан ноёрхох бодлого үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, биеэ даасан хөгжлийн замд орсон шинэ залуу улсуудад ихээхэн хор хохирол учруулж байна. Энэ бүгдээс үндэслэн зохиогч Бээжингийн эрх баригчид намжмал байдал, зэвсэг хураах явдал, хамтын аюулгүй байдлын эсрэг чухам яагаад тэгж махран тэмцээд байгаа юм бэ? гэсэн зүй ёсны асуулт тавиад бүх энх тайванч санаачилга «Бээжингийнхний их гүрний, жанжлах бодлогыг хэрэгжүүлэхэд саад учруулж байгаа учраас тэд уг чиг шугамыг хүлээн авахгүй байгаа нь бүхэнд тодорхой. Бээжингийн эрх баригчдын жанжлах их гүрний дээрэнгүй үзэл, бусдын газар нутаг руу шунахайран өнгөлзөх явдалтай нийцэхгүй байгаа учраас тэд намжмал байдал ба энх тайвны шугамыг дагахгүй байгаа юм» гэж хариулжээ.<sup>3</sup>

80-аад оноос бүхэл бүтэн бүс нутгийг өөрийн «амин чухал эрх ашгийн хүрээ» гэж зарлан, «олон улсын аллага хядлагатай тэмцэх» нэрийдлээр үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг нухчин дарах гэж оролдож буй АНУ-ын адал балмад бодлого олон улсын

<sup>2</sup>И. Коваленко. «Азийн энх тайван аюулгүй байдлын төлөө ЗХУ-ын тэмцэл». М., 274-р тал

<sup>3</sup>Мөн ном. 276-р тал.

байдлыг улам хурцатгаж байгаа өнөө үед И.  
Ко-

<sup>2</sup>И. Коваленко. «Азийн энх тайван аюулгүй байдлын төлөө ЗХУ-ын тэмцэл». М., 274-р тал  
<sup>3</sup>Мөн ном. 276-р тал.

валенкогийн толилуулан буй номын ач холбогдол бүр ч чухал юм.

Азийн энх тайван, хамтын аюулгүй байдлын төлөө тэмцлийн өнөөгийн үе шатанд гүн гүнзгий дүн шинжилгээ хийж, цаашдын хэтийн төлөвийг тодорхойлж өгсөнд энэ судалгааны үнэ цэнэ оршино. Зохиогч номынхоо төгсгөлд хамтын аюулгүй байдлын тухай зөвлөлтийн санал бол бэлэн төлөвлөгөө биш, Ази болон дэлхий дахинд гарсан өөрчлөлтийг харгалзан үзсэн үр бүтээлтэй үзэл санаа юм гээд Азийн орнууд хамтын үндсэн дээр нарийвчлан судлаж үзсэн шинэ санаачилга, санал дэвшүүлнэ гэдэгт итгэж байгаагаа илэр-

хийлжээ.

ЗХУ-аас дэвшүүлсэн Азийн хамтын аюулгүй байдлын тухай үзэл санаатай нягт уялдуулан Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох хүч үл хэрэглэх тухай конвенц байгуулах саналыг БНМАУ саяхан дэвшүүлсэн билээ. Энэ санал нь Азийн улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэх, Азид бат бэх энх тайван тогтоох явдалд тус дөхөм үзүүлэх гэсэн энхийг эрхэмлэгч монголын ард түмний хүсэл эрмэлзлийг илэрхийлж байгаа юм.

**Ц. Батбаяр**

**ЁСИДА МИНОРУ «МОНГОРУ ХАККЕН» ТОКИО, 1979, 309 р.  
(Ёсида Минору «Монголыг үзсэн нь» Токио. 1979)**

Японы улс төр, олон нийтийн зүтгэлтэн, парламентийн гишүүн Ёсида Минору 1978 онд БНМАУ-д айлчилсан хугацаандаа олж танилцсан баримт материалд түшиглэж «Монголыг үзсэн нь» (Нүүдэлчин үндэстний гайхамшиг) гэсэн ном бичиж хэвлүүлжээ. Уг ном «Монголын түүх ба Япон-Монголын харилцаа», «Орчин үеийн Монгол», «Монгол улс 1978 оны зун» гэсэн гурван хэсэг, «Эрт үеэс Монголын эзэнт гүрэн мөхөх хүртэл», «Ардын хувьсгалын дараахи Монгол орон», «Монголын ард түмний аж амьдрал», «Найрамдлын хот-Дархан» зэрэг 17 бүлгээс бүрджээ.

Зохиогч номдоо монголын ард түмний түүх, нийгэм соёл, зан заншлыг цухас дурдаад гол нь «цэцэглэн хөгжсөн социалист Монголын өнөөгийн дүр төрхийг өөрийн орны болон гадаадын өргөн олон уншигч нарт танилцуулахыг эрмэлзсэн» нь тэмдэглүүштэй 1939 оны Халх голын дайны үед Монголын хязгаарт долоо, найман жил амьдран сууж бас Өвөр Монголын нутагт ажиллаж байсан (энэ тухай зохиолч номынхоо оршилд дурджээ) Ёсида Минору 40 шахам жилийн дараа «Монголыг үзээд» тэр үеийг одоотой «зүйрлэхийн аргагүй» өөрчлөгдсөнийг нүдээр үзэгчийн хувьд өргөн олон уншигчдад танилцуулахад үнэхээр таарах хүн ажээ. Энэ хугацаанд монголын ард түмний социалист байгуулалтдаа олсон ололт амжилт хэдийгээр зүй тогтолтой хэрэг боловч зохиогчид «гайхамшиг» төрүүлэхгүй байж чадахгүй нь аргагүй юм. Ийм ч учраас зохиогч номоо «Нүүдэлчин үндэстний гайхамшиг» гэж давхар гарчиглажээ.

МАХН, БНМАУ-ын засгийн газраас ардын хувьсгалын жилүүдэд улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх талаар авч явуулсан дэс дараатай арга хэмжээнүүдийг зохиогч тодорхой тоо баримтад тулгуурлаж оновчтойгоор дүгнэн бичихдээ 1921 оны Ардын хувьсгалаас өмнө «Боловсрол гэгээрэл гэвэл сүм хийдүүдэд, төвд номыг хоосон цээжлүүлж, эмчилгээ сувилгаа гэвэл лам нарын гүрэм ном, шүтлэг бишрэл төдийхнөөр хязгаарлагдаж, нийгмийн халдварт өвчин дэлгэрэн, хүн ам хорогдож байсан» (25-р тал) Монгол орон одоо «Бичиг үсэг үл мэдэх явдлыг үүрд устгаж, соёл боловсролыг түгээн дэлгэрүүлж, ардын эрүүлийг хамгаалахыг хөгжүүлэхийн зэрэгцээгээр аж үйлдвэрийг, чухалчилан хөгжүүлснээр хоцрогдсон мал аж ахуйн орон эдүгээ аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болтлоо дэвшин дээшилж чадсан байна» (79, 96-р тал) гэжээ.

Зохиогч номдоо Монгол-Хятадын харилцааны байдал, Монголын эсрэг хятадын эзлэн түрэмгийлэгчдээс баримталж ирсэн чиг бодлого, сүүлийн үед Хятадын эрх баригчдаас БНМАУ-д учруулж байгаа аюул заналын талаар нилээд дэлгэрэнгүй бичжээ. Тухайлбал «Хятадууд монголыг түрэмгийлэн эзлэх бодлогыг баримталж ирсэн бөгөөд одоо ч баримталсаар байна. 1962 онд Монголын талын санаачилгаар Монгол Хятад хоёр улсын хилийн гэрээнд гарын үсэг зурсан боловч түүнээс хойш ч хятадын жанжлах үзэлтний түрэмгий бодлого зогсоогүй байна» гээд «Монголын ирээдүйг яагаад ч Бээжинд биш Улаанбаатарт шийдвэрлэх ёстой» (169